

**ХЭНТИЙ АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН
ДЭД ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Д/д	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх хугацаа	Зардлын эх үүсвэр /мян.төг/	Хэрэгжилт	Үнэлгээ
1	Судалгаа, мэдээ тайлан гаргах ажлын хүрээнд				
1.1	Дэд зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг холбогдох газруудад хүргүүлэх, төлөвлөгөөний дагуух хэрэгжилтийн тайланг гаргуулах, нэгтгэн дүгнэх	2, 4 дүгээр улирал	-	Аймгийн ОУИТБС-ын дэд зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийн тайланг гаргаж, нэгтгэн дүгнэж хүргүүлэв.	100
1.2	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн судалгааг гаргаж дэд зөвлөлийн гишүүд, холбогдох сумдад хүргүүлэх	Улирал бүр	-	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн судалгааг гаргаж, улирал бүр өөрчлөлт, шинэчлэлийг бүртгэн сумдад болон холбогдох байгууллагуудад хүргүүлж, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангаж ажиллалаа.	100
1.3	Орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хандив, дэмжлэгийн мэдээг гаргаж баталгаажуулан ОУИТБС-ын ажлын албанд цахимаар болон бичгээр хүргүүлэх	2 дугаар улиралд	-	Орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хандив, дэмжлэгийн тайлан мэдээг сумдаас болон холбогдох агентлаг байгууллагаас авч нэгтгэн, батлагдсан маягтын дагуу гаргаж цахимаар болон цаасаар ОУИТБС-ын ажлын албанд заасан хугацаанд хүргүүлсэн. Мөн тодруулга тайланг тухай бүр гаргаж баталгаажуулж хүргүүлсэн.	100
1.4	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, өөрчлөлт, тайлан, зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал, түүний зарцуулалт, буцаан төлөлтийн мэдээ тайланг аж ахуйн нэгж бүрээр гаргаж, дэд зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх, холбогдох газартай хамтран хяналт тавьж ажиллах	1, 4 дүгээр улиралд	-	16 ААН-ийн хайгуулын ажлын болон байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг хүлээн авч, баталгаажуулан ажиллаж байна. Байгалт орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл, нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авах ажлын хэсэг 14 ААН-д ажиллаж, холбогдох тайлан мэдээг гарган БОАЖЯам болон АМГТГ-т	100

				хүргүүлж, аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлд болон аймгийн ОУИТБС-ын дэд зөвлөлийн төлөөллүүдэд танилцуулж ажилласан.	
1.5	Байгаль орчны нөхөн сэргээлтийн талаарх мэдээ, тайланг аж ахуйн нэгж бүрээр гаргах	1 дүгээр улиралд	-	“Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээний Хэнтий аймагт хэрэгжүүлэх дэд төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Уул уурхайн эвдрэлд орсон Бор-Өндөр сумын 18.3 га талбайд 6 аж ахуйн нэгж нөхөн сэргээлт хийсэн. ОНТ-ийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаар Баян-Адарга, Дархан, Бор-Өндөр сумын эвдрэлд орсон 30 га газарт техникийн нөхөн сэргээлт, үүнээс 10 га-д биологийн нөхөн сэргээлт хийлээ. “Монголпросцветмет” ТӨҮГ дүйцүүлэх нөхөн сэргээлтийн хөтөлбөрийн хүрээнд Бэрх тосгоны уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдрэлд орсон 27 га газарт техникийн нөхөн сэргээлт хийхээс 22.8 га газрыг бүрэн дуусгаж аймгийн комисст актаар хүлээлгэж өглөө. Засгийн газрын 2021 оны "Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай" 281 дугаар тогтоолоор Чингис хот-Бэрх чиглэлийн авто замын ажлын дагуу нийт 10 түр карьер байгуулагдан ажиллаж байгаагаас ашиглаж дууссан 2 карьерийн нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэж, орон нутаг хүлээж аваад байна. Энэ онд нийт 70.0 га талбайд нөхөн сэргээлт хийхээр төлөвлөснөөс одоогоор 71.1 га талбайд хийгээд байна.	100

1.6	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулж, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн аймаг, сумдын Засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээ, гэрээний хэрэгжилтийг ОУИТБС болон холбогдох байгууллагад хүргүүлэх	2, 4 дүгээр улиралд	-	Аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч 164 ААН рүү Хамтран ажиллах гэрээ байгуулахаар гэрээний санал хүргүүлж, талууд баталгаажуулсан 60 гаруй гэрээг аймгийн албан ёсны вэб сайтад байршуулаад байна. 2021 онд байгуулсан 34 гэрээний хэрэгжилтийг 2022 оны 1 дүгээр сард дүгнэж ажилласан ба гэрээний хэрэгжилт 78.3 хувьтай хангагдсан. Гэрээний хэрэгжилтийг холбогдох газруудад хүргүүлж, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд уулзаль зохион байгуулж мэдээлэл өгч ажилласан.	100
1.7	Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалтын ажил зохион байгуулах	3 дугаар улиралд	БХНСЗ 1500,0	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг 3 удаа, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох хяналт шалгалтын ажлыг 1 удаа зохион байгуулсан. Давхардсан тоогоор 17 ААН хамрагдаж Байгаль орчныг хамгаалах тухай, Усны тухай, Газрын тухай болон бусад хууль тогтоомжийг зөрчиж олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанд илэрсэн зөрчлийг арилгах хүртэл үйл ажиллагааг түр зогсоож, 6 ААН-ий нүйл ажиллагааг түр зогсоож, Зөрчлийн тухай хуулийн дагуу 12500 нэгж торгууль ногдуулан, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлт гаргуулан, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллалаа. Мөн шалгалтын явцад нийт 616,287,326 төгрөгийн татварын ногдол үүсгэн төсөвт 238,057,116	100

				төгрөгийн орлого төвлөрүүлж, 378,230,210 төгрөгийн орлогын нэмэлт эх үүсвэр бүрдүүлснээс гадна өмнөх оны болон тайлант 17,065,302 төгрөгийн татварын өрийг барагдуулсан.	
2	Иргэдэд нээлттэй ил тод мэдээлэх, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд				
2.1	Аймгийн http://khentii.gov.mn цахим хуудасны тусгай зөвшөөрөл цэсэнд мэдээлэл тогтмол оруулах, хариуцлагатай уул уурхайн хүрээнд хийж буй арга хэмжээ, ажил үйлчилгээг олон нийтэд нээлттэй, ил тод сурталчлах	Улирал бүр	-	Аймгийн http://khentii.gov.mn цахим хуудсанд “Ил тод байдал” цэсийг нэмж уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй байгуулсан орон нутгийн Хамтын ажиллагааны гэрээнүүдийг байршуулан иргэд, олон нийтэд ил тод мэдээлж ажиллаж байна.	100
2.2	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид үйл ажиллагааны тайлан, нийгмийн хариуцлагын хүрээнд хийж буй арга хэмжээ, ажил үйлчилгээг тухайн орон нутгийн багийн иргэдийн нийтийн хурал, сумын ИТХ-д хэлэлцүүлж, олон нийтэд нээлттэй, ил тод тайлагнах ажлыг хэвшүүлэх	Жилийн турш	-	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд шаардлагатай, дутагдалтай байгаа мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх зорилготой “Зөгий үүр” төслийг хэрэгжүүлж ажиллаж байгаа ба мэдээллийг иргэд, олон нийтэд сар бүр ил тод хүргэж мэдээлж ажиллаж байна. Тус хөтөлбөрөөс 13 оюутан, 10 магистрантад тэтгэлэг олгож, орон нутагт дутагдалтай 6 мэргэжилтэнд дэмжлэг үзүүлж, тусгай мэргэжлийн сургалтад 55, чадавхижуулах сургалтад 6379 (давхардсан тоогоор) төрийн албан хаагчийг тус тус сургаж бэлтгээд байна.	100
2.3	Хөдөө сумдын иргэдийг мэдээллээр хангах зорилгоор эрх зүйн цахим хөтөч http://e-khutuch.mn/ , www.khentii.mn сайтаар дамжуулан мэдээлэл тогтмол хүргэх	Жилийн турш	-	Салбарын холбогдолтой мэдээ мэдээллийг тухай бүр албан ёсны цахим мэдээллийн хэрэгслүүд, сайтуудаар дамжуулан нээлттэй хүргэж байна.	100

3	Хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, чадавхи бэхжүүлэх ажлын хүрээнд				
3.1	Аймгийн ОУИТБС-ын дэд зөвлөлийн хурлыг зохион байгуулах, чадваржуулах сургалт, зөвлөгөөнд дэд зөвлөлийн гишүүд, иргэний нийгмийн төлөөллийг хамруулах	Тухай бүр	-	2022 оны 10-р сарын 27-28-ний өдөр “Зүүн бүсийн аймгуудын олборлох салбарын ил тод байдал”-ын нэгдсэн чуулга уулзалтад 4 сумын 20 орчим дэд зөвлөлийн болон олон талт хяналтын зөвлөлийн гишүүдийг хамрууллаа. ОУИТБС-ын ажлын албанаас зохион байгуулсан цахим сургалт, хэлэлцүүлэгт болон 11 сарын 21-22-ны өдөр зохион байгуулагдсан ОУ-ын чадавхижуулах сургалтад Дэд зөвлөлийн нарийн бичиг хамрагдсан.	100
3.2	Төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр албан уулзалт зохион байгуулах	2, 4 дүгээр улиралд	-	Орон нутагт төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагуудын дарга, удирдах ажилтнуудтай зөвлөгөөн зохион байгуулж, уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбарт уялдаа холбоотой ажиллаж, төлөвлөгөөт хяналт шалгалтыг нэгдсэн зохион байгуулалттай аймгийн Засаг даргын нэгдсэн удирдамжаар ажиллахыг чиглэл болгож, 2022 оны үр дүнгийн гэрээ болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулан батлуулсан.	100
3.3	Төр, хувийн хэвшлийн түншлэл, иргэний нийгмийн харилцан ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор уулзалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулах	Жилдээ	ОНТ 6000,0	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчидийн уулзалтыг зохион байгуулж салбарын талаар аймгийн баримталж буй бодлого чиглэл, хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлж ажиллах талаар мэдээлэл өгч, хамтран ажиллах гэрээний төсөлд санал авч баталгаажуулах, өмнөх жилийн гэрээг дүгнэх уулзалтыг 3-р сард зохион байгуулж 80 гаруй ААН-ийн 130 орчим төлөөлөл оролцсон. Мөн	100

				аймгийн уул уурхайн салбарын зөвлөгөөнийг 5-р сард зохион байгуулж, уул уурхай бүхий сумдын удирдлагууд, иргэд малчид, нөхөрлөл бүлгүүдийн төлөөллүүд, уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд болон холбогдох үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллагуудын удирдлагууд нийт 180 гаруй хүн оролцож салбарын үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчилж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулах талаар харилцан зөвшилцөж хамтран ажиллалаа.	
--	--	--	--	---	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

АЙМГИЙН ОУИТБС-ЫН ДЭД ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХБТХОХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  Б.МӨНХЖАРГАЛ